

БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ДҮРМИЙН ТАНИЛЦУУЛГА

Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийг Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.10-д заасныг үндэслэн Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 68 дугаар тогтоолоор батлуулсан бөгөөд 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 171 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Дүрмийн хэрэгжилтийн явцад холбогдох нэмэлт өөрчлөлт, сайжруулалт оруулах шаардлагууд тулгараад байгаа бөгөөд жишээлбэл, Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д заасан онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн ангилалд хамаарах барилга байгууламжид эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох болон ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулахад зарим аймаг, орон нутагт байгууллагын орон тоо, инженер техникийн ажилчид дутмаг байдлаас болж шийдвэрлэх боломжгүй байгаа талаарх хүсэлтийг тус яаманд удаа дараа ирүүлэх асуудал тулгардаг. Мөн эрчим хүчний салбарын барилга байгууламжид эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгохдоо Эрчим хүчний сайдын 2018 оны 92 дугаар тушаалаар баталсан “Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам”-ыг мөрдөж байгаа нь Барилгын тухай хууль, Эрчим хүчний тухай хуульд нийцэхгүй байгаа юм.

Уг тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэх үүднээс дүрмийн төслийг шинэчлэн боловсруулсан бөгөөд Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д заасан онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн ангилалд хамаарах барилга байгууламжид эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг аймаг нийслэлийн Засаг даргын хүсэлтийг үндэслэн барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэх зохицуулалтыг тусгасан. Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т хамаарах барилга байгууламжийн барилгын ажлын зөвшөөрлийг олгох асуудлыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэх зохицуулалтыг, мөн барилга байгууламжийн буулгалтын ажлын зөвшөөрөл олгох зохицуулалтыг нэмэлтээр тус тус оруулсан.

Түүнчлэн Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5-д хамаарах барилга байгууламжийн барилгын ажлын зөвшөөрлийг олгох асуудлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэх зохицуулалтыг тусгасан.

Барилгын ажлын зөвшөөрөл олгогдоогүй барилга байгууламжид барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл нөхөж олгох асуудал ихээхэн гардаг бөгөөд уг асуудлыг мэргэжлийн хяналтын байцаагчийн дүгнэлтээр бус шүүхээр шийдвэрлүүлсний үндсэн дээр шийдэх заалтыг шинээр оруулж өгсөн болно.

Уг дүрмийг төслийг батлах төслийг аймаг, нийслэлийн барилгын асуудал эрхэлсэн төрийн байгууллагуудад цахим хэлбэрээр, болон салбарын төрийн бус байгууллагуудад тус тус танилцуулж хэлэлцүүлгийн мөрөөр ирүүлсэн саналуудыг тусгасан болно.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны . . . дугаар
сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.10-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт, нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм батлах тухай” Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 68 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Барилгын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1¹-д зааснаар барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл (цаашид “барилгын ажлын зөвшөөрөл” гэх) олгох болон улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хийгдэх гадна тохижилт, барилга байгууламжийг засварлах, тоноглох ажлын зөвшөөрөл олгох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1²-д заасан барилга байгууламжид уг дүрэм хамаарахгүй ба барилгын ажлын захиалагч (цаашид “захиалагч” гэх)-д шаардлагатай тохиолдолд энэхүү дүрмийг жишиг болгон мөрдөж болно.

Хоёр. Барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлт гаргах

2.1. Захиалагч барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлт гаргахдаа Барилгын тухай хуулийн 28³ дугаар зүйлийн 28.2, 28.3, 28.4-т заасан баримт бичгийг бүрдүүлнэ.

2.2. Захиалагч барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлтээ барилга байгууламжийн төвөгшлийн⁴ ангилалаас хамааран дараах зөвшөөрөл олгох байгууллагын аль нэгэнд хүргүүлнэ. Үүнд:

2.2.1. Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2⁵-т заасан барилга байгууламжийн барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлтээ барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад;

2.2.2. Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5⁶-д заасан барилга байгууламжийн барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлтээ холбогдох төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад;

2.2.3. Энэ дүрмийн 2.2.1, 2.2.2-т зааснаас бусад буюу Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2⁷, 10.1.3⁸, 10.1.4⁹, 10.1.5¹⁰-д заасан барилга

¹ 26.1. Энэ хуулийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д заасан ангилалд хамаарах барилга байгууламжид дараахь төрлөөр барилгын ажлын зөвшөөрөл олгоно:

² 10.1.1. барилгын ажлын зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламж;

³ 28 дугаар зүйл. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгох

⁴ 4.1.39. “төвөгшил” гэж барилга байгууламжийн бүтээц, технологи, эзлэхүүн төлөвлөлт, инженерийн шийдэл, хийцийн төрлөөс хамаарч зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх төлөв байдлыг;

⁵ 20.2. Цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 30 метрээс дээш өндөр, 60 метрээс дээш алгасалтай байгууламж, 16-аас дээш давхартай барилга, ус, дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг зөвхөн тухайн барилга байгууламжийн хувьд олгоно

⁶ 32.1.5. цөмийн болон дулааны цахилгаан станц, усан цахилгаан станц, төмөр зам, нисэх онгоцны буудал, метро, улс дамнасан нефть болон хийн хоолой, газрын тос боловсруулах үйлдвэр, түүхий тос дамжуулах хоолой зэрэг улсын чанартай барилга байгууламжид барилгын ажлын зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэх;

⁷ 10.1.2. бага төвөгшилтэй барилга байгууламж;

⁸ 10.1.3. дунд зэргийн төвөгшилтэй барилга байгууламж;

⁹ 10.1.4. өндөр төвөгшилтэй барилга байгууламж;

¹⁰ 10.1.4. өндөр төвөгшилтэй барилга байгууламж;

байгууламжийн барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлтийг аймаг, нийслэлийн Засаг даргад.

2.3. Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д заасан барилга байгууламжийн барилгын ажлын зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг даргын хүсэлтийг үндэслэн барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохих журмын дагуу шийдвэрлэж болно.

Гурав. Барилгын ажлын зөвшөөрөл олгох

3.1. Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.5-д хамаарах барилга байгууламжийн барилгын ажлын зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга энэ дүрмийн 2.1-д заасан баримт бичгийн бүрдэл, Барилгын тухай хууль болон энэхүү дүрэмд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, барилгын ажлын зөвшөөрлийг олгоно.

3.2. Энэхүү дүрмийн 2.3-т заасан хүсэлтийг үндэслэн Барилгын тухай хуулийн 10.1.5-д заасан барилга байгууламжийн барилгын ажлын зөвшөөрлийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Барилгын тухай хууль болон энэхүү дүрэмд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, барилгын ажлын зөвшөөрлийг олгоно.

3.3. Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасан барилга байгууламжийн барилгын ажлын зөвшөөрлийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэхүү дүрмийн 2.1-д заасан баримт бичгийн бүрдэл, Барилгын тухай хууль болон энэхүү дүрэмд заасан шаардлагыг хангасан гэж үзвэл барилгын ажлын зөвшөөрлийг олгоно.

3.4. Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5-д заасан барилга байгууламжийн барилгын ажлын зөвшөөрлийг дараах журмын дагуу Засгийн газар шийдвэрлэнэ. Үүнд:

3.4.1. захиалагчийн хүсэлтийг хүлээн авсан холбогдох төрийн захиргааны төв байгууллага нь энэхүү дүрмийн 2.1-д заасан баримт бичгийн бүрдлийг шалгаж, барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлтийг хүргүүлнэ;

3.4.2. барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Барилгын тухай хууль болон энэхүү дүрэмд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлнэ.

3.5. Барилгын ажлын захиалагчийн хүсэлтийг хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх эрх бүхий байгууллага нь хүлээн авч Барилгын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2¹¹-т заасан хугацаанд барилгын ажлын зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэнэ.

¹¹ 27.2. Энэ хуулийн 28.2-т заасан баримт бичгийг үндэслэн барилгын ажлын зөвшөөрлийг энэ хуулийн 27.1-д заасан байгууллага ажлын 10 өдөрт багтаан олгоно.

3.6. Зөвшөөрөл олгох байгууллага барилгын ажлын зөвшөөрөл авах хүсэлтийг хянах явцад шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагаас тодруулга авч болно.

3.7. Энэхүү дүрмийн 3.6-д заасан тодруулга авсан тохиолдолд барилгын ажлын зөвшөөрөл олгох хугацааг дүрмийн 3.5-д зааснаар дахин авч үзнэ.

3.8. Барилгын ажлын зөвшөөрлийг барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд заасан графикт хугацаа буюу барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар олгоно.

3.9. Цогцолбор барилгын ажлын зөвшөөрөл олгохдоо цогцолборын эх загвар зургийн магадлалын дүгнэлтэд үндэслэн шийдвэрлэнэ.

3.10. Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 20 дугаар зүйлийн 20.2, 32 дугаар зүйлийн 32.1.5-д хамаарах барилга байгууламжийн хувьд шаардлагатай тохиолдолд инженерийн бэлтгэл ажилд барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгож болно.

3.11. Барилга байгууламжийн буулгалтын ажлын зөвшөөрлийг Барилгын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3¹²-т заасан зураг төсөл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга хэмжээний төлөвлөгөө, буулгах ажлын технологит үндэслэн шийдвэрлэнэ.

Дөрөв. Барилга байгууламжийн зөвшөөрлийн гэрчилгээ олгох, татгалзах

4.1. Барилгын ажлын зөвшөөрлийг энэхүү дүрмийн 1 дүгээр хавсралтад заасан гэрчилгээгээр баталгаажуулан олгоно.

4.2. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг 2 хувь үйлдэж, захиалагчид 1 хувийг, архивт 1 хувийг тус тус олгоно. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ нь энэхүү дүрмийн 2, 3 дугаар хавсралтад заасан хугацаа сунгах, нэмэлт, өөрчлөлтийг бүртгэх хавсралтуудтай байна.

4.3. Захиалагч барилгын ажлын явцад дараах өөрчлөлт гарсан тохиолдолд Барилгын тухай хууль болон энэхүү дүрэмд заасны дагуу зохих арга хэмжээг авч, зөвшөөрөл олгосон байгууллагад тухай бүрт нь мэдэгдэж гэрчилгээнд дараах өөрчлөлт оруулна. Үүнд:

4.3.1. барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд заасан мэдээлэлд өөрчлөлт орох;

4.3.2. гүйцэтгэгч, захиалагч болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэх байгууллага өөрчлөгдөх;

4.3.3. гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрлийн хугацаа дуусах;

4.3.4. зураг төсөлд үндсэн хийц бүтээцэд өөрчлөлт орох;

¹² 16.3.Барилга байгууламжийн угсралт, буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажлын талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөл боловсруулна.

4.3.5. дуусаагүй барилга байгууламжийг хамгаалалтын горимд оруулах болон уг хугацаа дуусгавар болох.

4.4. Зөвшөөрөл олгох байгууллага барилгын ажлын явцад өөрчлөлт орсон тохиолдол бүрт энэхүү дүрмийн 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу өөрчлөлтийг бүртгэж, гэрчилгээнд хавсаргана.

4.5. Барилгын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2¹³-т заасны дагуу барилгын ажлын зөвшөөрлийн хугацааг сунгасан тохиолдолд энэхүү дүрмийн 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бүртгэж, гэрчилгээнд хавсаргана.

4.6. Барилгын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-т заасан хугацаанд сунгуулах хүсэлтээ ирүүлээгүй Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг хүчингүйд тооцож, барилгын ажлын зөвшөөрлийг шинээр авах нөхцөл үүснэ.

4.7. Зөвшөөрөл олгох байгууллага дараах үндэслэлээр барилгын ажлын зөвшөөрөл олгохоос татгалзаж, энэ тухай захиалагчид бичгээр мэдэгдэнэ. Үүнд:

4.7.1. баримт бичгийн бүрдэл дутуу, эсхүл хуурамчаар бүрдүүлсэн;

4.7.2. баримт бичиг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлага (гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч болон өргөх байгууламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын тусгай зөвшөөрлийн болон техникийн нөхцөлийн хугацаа дуусгавар болсон, байршил, газар олголт, төлөвлөлтийн болон норматив баримт бичгийн шаардлагыг зөрчсөн)-д нийцээгүй.

Тав. Бусад

5.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгож болно.

5.2. Захиалагч барилгын ажлын зөвшөөрлийн талаарх мэдээллийг барилгын ажлын талбайн мэдээллийн самбарт байрлуулна.

5.3. Зөвшөөрөл олгосон байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд барилгын ажлын зөвшөөрөл олгосон, цуцалсан, хугацаа сунгасан зэрэг асуудлаар тухай бүр бүртгэл хөтөлж барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хот байгуулалтын кадастрын цахим мэдээллийн санд байршуулж, нэгдсэн тайланг хагас жил тутам нэгтгэн гаргаж барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.4. Зөвшөөрөл олгосон байгууллага нь барилгын ажлын зөвшөөрөл олгосон талаарх мэдээллийг ажлын 5 өдөрт багтаан барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад тус тус хүргүүлнэ.

5.5. Барилгын ажлын зөвшөөрөл зохих ёсоор олгогдоогүй барилга байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэхийг хориглоно.

¹³ 30.2. Барилгын ажил энэ хуулийн 30.1-д заасан хугацаанд дуусаагүй бол захиалагч зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө сунгуулах хүсэлтийг энэ хуулийн 27.1-д заасан байгууллагад гаргаж, дуусаагүй ажлыг гүйцэтгэх бодит хугацааг тусгасан төлөвлөгөөг хавсаргана.

5.6. Барилгын ажлын зөвшөөрөл олгогдоогүй барилга байгууламжид барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл нөхөж олгохыг хориглох ба **уг асуудлыг шүүхээр шийдвэрлүүлсний үндсэн дээр** шийдвэрлэнэ.

5.7. Зөвшөөрөл олгох байгууллага нь энэхүү дүрмийг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ

-----o0o-----

БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

(Загвар)

- Барилга байгууламжийг шинээр барих
- Барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх
- Барилга байгууламжийг засварлах, тоноглох
- Буулгалтын ажил
- Гадна талбайн тохижилт

.....
/Аймаг, хотын нэр/

.....
/Зөвшөөрөл олгосон огноо/

.....
/Зөвшөөрлийн дугаар/

1. Барилга байгууламжийн байршлын талаарх мэдээлэл:

..... аймаг /нийслэл/, сум /дүүрэг/,
..... баг /хороо/, гудамж /хороолол/;

2. Газрын эрхийн бүртгэлийн мэдээлэл:

Иргэний хувьд: харьяалал /аль улсын/,
..... овог, эцэг /эх/-ийн нэр, нэр

Хуулийн этгээдийн хувьд: оноосон нэр, улсын
бүртгэлийн гэрчилгээний дугаар, газрын эрхийн
хэлбэр (өмчлөх, эзэмших, ашиглах), газрын зориулалт,
..... талбайн хэмжээ, газар эзэмших,
ашиглах хугацаа, кадастрын код;

3. Барилгын ажлын зөвшөөрлийн хүчинтэй хугацаа:

..... барилгын ажил гүйцэтгэх графикт хугацаа;

4. Барилга байгууламжийн талаарх мэдээлэл:

..... зориулалт, хүчин чадал,
..... үндсэн хийц, хэмжээ, давхрын тоо,
хэсэг/блок/, зураг төслийн шифр дугаар;

5. Барилга байгууламжийн ангилал: төвөгшилтэй
барилга байгууламж;

6. Барилгын ажлын захиалагчийн талаарх мэдээлэл:

Иргэний хувьд: харьяалал /аль улсын/,
..... овог, эцэг /эх/-ийн нэр, нэр
хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/ баг /хороо/,
..... гудамж /хороолол/ байр /хашаа, хаалга/-ны дугаар,
..... холбоо барих утас, цахим хаяг;

Хуулийн этгээдийн хувьд: оноосон нэр, улсын
бүртгэлийн гэрчилгээний дугаар,

хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/ баг
/хороо/, гудамж /хороолол/ байр /хашаа, хаалга/-ны
дугаар, холбоо барих утас, цахим
хаяг;

7. Барилгын зураг төсөл зохиогчийн талаарх мэдээлэл:

..... хуулийн этгээдийн оноосон нэр, улсын бүртгэлийн
гэрчилгээний дугаар, зураг төсөл боловсруулах тусгай
зөвшөөрлийн гэрчилгээний дугаар,

хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/ баг /хороо/,
..... гудамж /хороолол/ байр /хашаа, хаалга/-ны дугаар,
..... холбоо барих утас, цахим хаяг;

8. Барилгын ажлын гүйцэтгэгчийн талаарх мэдээлэл:

..... хуулийн этгээдийн оноосон нэр, улсын бүртгэлийн
гэрчилгээний дугаар, барилгын ажил гүйцэтгэх тусгай
зөвшөөрлийн гэрчилгээний дугаар,

хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/ баг
/хороо/, гудамж /хороолол/ байр /хашаа, хаалга/-
ны дугаар, холбоо барих утас,
цахим хаяг;

9. Онцгойлон заах нөхцөл:

.....
..... ;

10. Барилгын ажлын зөвшөөрөл олгосон албан тушаалтны мэдээлэл:
..... байгууллагын нэр, албан тушаал,
..... овог нэр, / / гарын үсэг, (тамга, тэмдэг)

Тайлбар: Цахим хэлбэрээр Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг үзэх
боломжийг бүрдүүлэх боломжтой байдлаар өгөгдөл хадгалах QR код нэмж болно.

БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

.....
/Барилгын ажлын зөвшөөрөл сунгасан огноо/

1. Барилгын ажлын зөвшөөрлийн хугацааг сунгах
шалтгаан:.....;

2. Барилгын ажлын төлөв байдал:үе шат,
..... гүйцэтгэсэн ажлын нэр, төрөл;

3. Барилгын ажил гүйцэтгэх хугацаа:

4. Барилгын ажлын зөвшөөрлийн хугацааг сунгасан ажилтны мэдээлэл:
.....байгууллагын нэр,албан тушаал,
.....овог нэр,...../ /гарын үсэг, (тамга,
тэмдэг).